

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ, АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Ч.ХҮРЭЛБААТАР**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслүүдийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2015 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас нягтлан бодох бүртгэл, аудитын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлд олон улсын стандартыг мөрдүүлэх, эдийн засгийн өсөлт, төсвийн орлогыг хангахад нягтлан бодох бүртгэлийн үүргийг нэмэгдүүлэх, санхүүгийн тайланг тайлагнах үед бизнес эрхлэгчдэд учирч буй хүндрэлийг бууруулах, аудитын байгууллага, аудиторт тавих шаардлагыг өндөржүүлэх, аудитын үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж, тэдгээрийн үйл ажиллагааны чанарт хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар төрийн үйлчилгээг 20 гаруй жил амжилттай хэрэгжүүлж ирсэн институтын тогтвортой байдлыг алдагдуулах нь буруу, өнөөдрийг хүртэл нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэхээр явж байгаа мэргэшсэн нягтлан бодогчийн институтын оноосон нэрийг хуулинд зааж өгөх хэрэгтэй, аж ахуйн нэгжүүд заавал ерөнхий нягтлан бодогчтой байхаар тусгасныг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргал мэргэшсэн нягтлан бодогчийн институтыг хуулинд тусгайлан нэр зааж хуульчилж болохгүй, мэргэшсэн нягтлан бодогч нар сайн дурын үндсэн дээр институтын үйл ажиллагааг эрхэлж явуулах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон даган өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн

оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.БОЛОР